

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** СЭА-2022/136-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](http://www.selenge@audit.gov.mn)  
Сүхбаатар сум  
2022 он

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа  
Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх  
Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: Эн Ай Ти Эс Баланс аудит  
ХХК  
Утас: 77270808 Цахим хаяг: [nitsbalance@gmail.com](mailto:nitsbalance@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3.Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл,нэмэлт төсөв.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4.1 Залруулсан алдаа.....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны Яам
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
ИТХ	Иргэдийн төлөөгчдийн хурал
ОНӨГ	Орон Нутгийн Өмчийн Газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

210200, Сэлэнгэ аймаг, Бүхбаатар сум  
Сүхбаатар 3-р хороо, 11-д тогт  
Утас: 7035-3043, Факс: (976) 7035-3040  
E-mail: [science@audit.gov.mn](mailto:science@audit.gov.mn)

2022.02.25 № СЭА-2022/136-НА-СТА-ТШЗ

Танайд \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

СЭА-2022/136-НА-СТА-ТШЗ


018020217  
3

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан/  
/төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>45,355,263.00</b>	<b>40,832,054.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>45,355,263.00</b>	<b>40,832,054.00</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>3,450,012.00</b>	<b>2,669,398.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	3,450,012.00	2,669,398.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>41,905,251.00</b>	<b>38,162,656.00</b>
35410	Бичиг хэргийн материал	3,009,551.00	2,575,451.00
35450	Барилгын засварын материал	799,200.00	799,200.00
35460	Хүнсний материал	462,050.00	636,400.00
35470	Бусад хангамжийн материал	37,634,450.00	34,151,605.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,532,739,495.64</b>	<b>1,549,928,220.04</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,532,739,495.64</b>	<b>1,549,928,220.04</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,484,810,745.58</b>	<b>1,454,604,469.98</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,414,166,879.00	1,414,166,879.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-35,643,534.60	-62,353,966.92
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	63,156,347.40	62,424,178.84
39206	Хуримтлагдсан элэгдэл	-27,279,080.46	-26,337,450.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,851,815.94	25,585,794.94
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,693,820.42	-14,286,251.68
39214	Бусад үндсэн хөрөнгө	67,337,844.00	67,337,844.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,085,705.28	-11,932,557.96
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>47,928,750.06</b>	<b>95,323,750.06</b>
39301	Программ хангамж	1,750,000.00	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-531,249.94	-656,249.94
39303	Бусад биет бус хөрөнгө	46,710,000.00	94,330,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,578,094,758.64</b>	<b>1,590,760,274.04</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,578,094,758.64</b>	<b>1,590,760,274.04</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,578,094,758.64</b>	<b>1,590,760,274.04</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	353,183,767.00	400,803,767.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,062,467,927.20</b>	<b>1,027,513,442.60</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,092,296,954.31	1,062,467,927.20
51220	Тайлант үеийн үр дүн	-29,829,027.11	-34,954,484.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	162,443,064.44	162,443,064.44
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,578,094,758.64</b>	<b>1,590,760,274.04</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан/  
/төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>556,968,193.30</b>	<b>516,504,442.61</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,402,940.00</b>	<b>5,545,517.84</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>5,402,940.00</b>	<b>5,545,517.84</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	5,248,500.00	4,634,171.84
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	154,440.00	911,346.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>551,565,253.30</b>	<b>510,958,924.77</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>510,416,100.00</b>	<b>466,861,600.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	510,416,100.00	466,861,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0.00</b>	<b>126,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	126,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>41,149,153.30</b>	<b>43,971,324.77</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,149,153.30	43,971,324.77
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>586,642,780.41</b>	<b>551,458,927.21</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>586,642,780.41</b>	<b>551,458,927.21</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>542,088,221.20</b>	<b>534,724,714.73</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>374,752,536.07</b>	<b>359,392,282.95</b>
210101	Үндсэн цалин	274,526,880.52	247,056,634.95
210102	Нэмэгдэл	74,513,433.53	96,708,367.00
210104	Урамшуулал	25,712,222.02	15,627,281.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>48,209,718.72</b>	<b>49,299,179.57</b>
210201	Тэтгэврийн даатгал	31,262,106.75	34,804,403.24
210202	Тэтгэмжийн даатгал	5,116,382.52	3,639,425.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,642,445.84	2,898,000.85
210204	Ажилгүйдлийн даатгал	742,617.72	722,824.31
210205	Эрүүл мэндийн даатгал	8,446,165.89	7,234,525.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>41,149,153.30</b>	<b>43,448,424.77</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,417,163.30	3,229,724.77
210302	Түлш, халаалт	32,355,700.00	33,947,400.00
210303	Цэвэр, бохир ус	5,376,290.00	6,271,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,450,916.00</b>	<b>9,919,150.00</b>
210401	Бичиг хэрэг	1,100,000.00	739,100.00
210402	Тээвэр, шатахуун	397,850.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	769,666.00	761,245.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,052,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,131,400.00	1,892,991.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	6,225,814.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>26,450,700.00</b>	<b>23,347,970.00</b>

Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	93,000.00	263,390.00
210502	Хоол, хүнс	26,357,700.00	23,084,580.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,572,500.00</b>	<b>3,293,360.00</b>
210604	Урсгал засвар	3,572,500.00	3,293,360.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>148,900.00</b>	<b>265,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	148,900.00	265,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>574,000.00</b>	<b>1,698,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	250,000.00	402,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	1,296,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>42,779,797.11</b>	<b>44,061,147.44</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,015,900.00	1,300,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,763,897.11	42,761,147.44
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>44,554,559.21</b>	<b>16,734,212.48</b>
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>44,554,559.21</b>	<b>16,734,212.48</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,554,559.21	16,734,212.48
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-29,674,587.11</b>	<b>-34,954,484.60</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>154,440.00</b>	<b>0.00</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	154,440.00	0.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-29,829,027.11</b>	<b>-34,954,484.60</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	353,183,767.00	162,443,064.44	1,062,467,927.20	1,578,094,758.64
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	353,183,767.00	162,443,064.44	1,062,467,927.20	1,578,094,758.64
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	47,620,000.00	0.00	0.00	47,620,000.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-34,954,484.60	-34,954,484.60
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	400,803,767.00	162,443,064.44	1,027,513,442.60	1,590,760,274.04

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан/  
/төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>551,565,253.30</b>	<b>510,958,924.77</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>551,565,253.30</b>	<b>510,958,924.77</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>510,416,100.00</b>	<b>466,861,600.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	510,416,100.00	466,861,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0.00</b>	<b>126,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	126,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>41,149,153.30</b>	<b>43,971,324.77</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,149,153.30	43,971,324.77
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>545,374,453.30</b>	<b>503,263,224.77</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>545,374,453.30</b>	<b>503,263,224.77</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>500,819,894.09</b>	<b>486,529,012.29</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>374,752,536.07</b>	<b>359,392,282.95</b>
210101	Үндсэн цалин	274,526,880.52	247,056,634.95
210102	Нэмэгдэл	74,513,433.53	96,708,367.00
210104	Урамшуулал	25,712,222.02	15,627,281.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>48,209,718.72</b>	<b>49,299,179.57</b>
210201	Тэтгэврийн даатгал	31,262,106.75	34,804,403.24
210202	Тэтгэмжийн даатгал	5,116,382.52	3,639,425.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,642,445.84	2,898,000.85
210204	Ажилгүйдлийн даатгал	742,617.72	722,824.31
210205	Эрүүл мэндийн даатгал	8,446,165.89	7,234,525.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>41,149,153.30</b>	<b>43,448,424.77</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,417,163.30	3,229,724.77
210302	Түлш, халаалт	32,355,700.00	33,947,400.00
210303	Цэвэр, бохир ус	5,376,290.00	6,271,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,424,916.00</b>	<b>4,310,245.00</b>
210401	Бичиг хэрэг	1,100,000.00	1,369,000.00
210402	Тээвэр, шатахуун	397,850.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	769,666.00	761,245.00
210404	Ном, хэвлэл	106,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,052,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,999,400.00	1,880,000.00

Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>24,613,070.00</b>	<b>23,522,320.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	93,000.00	263,390.00
210502	Хоол, хүнс	24,280,070.00	23,258,930.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	240,000.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,931,700.00</b>	<b>3,293,360.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,359,200.00	0.00
210604	Урсгал засвар	3,572,500.00	3,293,360.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>148,900.00</b>	<b>265,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	148,900.00	265,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>574,000.00</b>	<b>1,698,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	250,000.00	402,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	1,296,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,015,900.00</b>	<b>1,300,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,015,900.00	1,300,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>44,554,559.21</b>	<b>16,734,212.48</b>
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>44,554,559.21</b>	<b>16,734,212.48</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,554,559.21	16,734,212.48
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>6,190,800.00</b>	<b>7,695,700.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>6,190,800.00</b>	<b>7,695,700.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,190,800.00</b>	<b>7,695,700.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>6,190,800.00</b>	<b>7,695,700.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,190,800.00	7,695,700.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-6,190,800.00</b>	<b>-7,695,700.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан/  
/төгрөг/*

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>547,182,100.00</b>	<b>494,098,712.29</b>	<b>53,083,387.71</b>	<b>90.3</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>547,182,100.00</b>	<b>494,098,712.29</b>	<b>53,083,387.71</b>	<b>90.3</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>547,182,100.00</b>	<b>494,098,712.29</b>	<b>53,083,387.71</b>	<b>90.3</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>364,400,300.00</b>	<b>359,392,282.95</b>	<b>5,008,017.05</b>	<b>98.6</b>
210101	Үндсэн цалин	282,730,500.00	247,056,634.95	35,673,865.05	87.4
210102	Нэмэгдэл	66,041,200.00	96,708,367.00	-30,667,167.00	146.4
210104	Урамшуулал	15,628,600.00	15,627,281.00	1,319.00	100.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд</b>	<b>49,761,000.00</b>	<b>49,299,179.57</b>	<b>461,820.43</b>	<b>99.1</b>

Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	төлөх шимтгэл				
210201	Тэтгэврийн даатгал	35,185,000.00	34,804,403.24	380,596.76	98.9
210202	Тэтгэмжийн даатгал	3,644,000.00	3,639,425.77	4,574.23	99.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,915,200.00	2,898,000.85	17,199.15	99.4
210204	Ажилгүйдлийн даатгал	728,800.00	722,824.31	5,975.69	99.2
210205	Эрүүл мэндийн даатгал	7,288,000.00	7,234,525.40	53,474.60	99.3
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>79,797,600.00</b>	<b>43,448,424.77</b>	<b>36,349,175.23</b>	<b>54.4</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,800,000.00	3,229,724.77	5,570,275.23	36.7
210302	Түлш, халаалт	38,797,600.00	33,947,400.00	4,850,200.00	87.5
210303	Цэвэр, бохир ус	32,200,000.00	6,271,300.00	25,928,700.00	19.5
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,184,500.00</b>	<b>4,184,245.00</b>	<b>255.00</b>	<b>100.0</b>
210401	Бичиг хэрэг	750,000.00	1,369,000.00	-619,000.00	182.5
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	0.00	300,000.00	0.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	984,000.00	761,245.00	222,755.00	77.4
210404	Ном, хэвлэл	120,500.00	0.00	120,500.00	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	430,000.00	174,000.00	256,000.00	40.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,600,000.00	1,880,000.00	-280,000.00	117.5
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>34,472,100.00</b>	<b>23,522,320.00</b>	<b>10,949,780.00</b>	<b>68.2</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	263,400.00	263,390.00	10.00	100.0
210502	Хоол, хүнс	34,208,700.00	23,258,930.00	10,949,770.00	68.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,012,900.00</b>	<b>10,989,060.00</b>	<b>23,840.00</b>	<b>99.8</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,700,000.00	4,695,700.00	4,300.00	99.9
210602	Тавилга	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	3,312,900.00	3,293,360.00	19,540.00	99.4
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>470,000.00</b>	<b>265,200.00</b>	<b>204,800.00</b>	<b>56.4</b>
210702	Дотоод албан томилолт	470,000.00	265,200.00	204,800.00	56.4
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,783,700.00</b>	<b>1,698,000.00</b>	<b>85,700.00</b>	<b>95.2</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	487,700.00	402,000.00	85,700.00	82.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,296,000.00	1,296,000.00	0.00	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,300,000.00</b>	<b>1,300,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,300,000.00	1,300,000.00	0.00	100.0

III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>547,182,100.00</b>	<b>494,098,712.29</b>	<b>53,083,387.71</b>	<b>90.3</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>466,861,600.00</b>	<b>450,127,387.52</b>	<b>16,734,212.48</b>	<b>96.4</b>
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	466,861,600.00	450,127,387.52	16,734,212.48	96.4
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>80,320,500.00</b>	<b>43,971,324.77</b>	<b>36,349,175.23</b>	<b>54.7</b>
320001	Орон нутгийн төсвөөс	80,320,500.00	43,971,324.77	36,349,175.23	54.7
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>275.00</b>	<b>248.00</b>	<b>27.00</b>	<b>90.1</b>
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	0.00	100
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>35.00</b>	<b>36.00</b>	<b>1.00</b>	<b>99.8</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	11.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	23.00	24.00	-1.00	104

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан/  
/төгрөг/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>126,000.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>126,000.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>126,000.00</b>
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>126,000.00</b>
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	126,000.00
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>126,000.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>126,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	126,000.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн

/ цаашид Мандал сумын 2 дугаар цэцэрлэг гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд цахим төлбөрийн баримтын системийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу аудитыг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-ийн аудитор Г.Хүрэл хариуцаж хэрэгжүүлэв. Аудитын чанарын анхан шатны хяналтыг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-ийн менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, дараагийн шатны чанарын хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар гүйцэтгэв.

Мандал сумын 2 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Мандал сумын 2 дугаар цэцэрлэг нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулан хүүхэд бүрийг бүтээлч үйлээрээ хөгжих чадварт суралцахад бүх талууд хамтарч дэмжлэг үзүүлнэ” гэж тодорхойлсон ба дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Сургалтын үйл ажиллагааг гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн үед тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж цахим хичээл дасгал даалгаврын сантай болох;
- Эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх;
- Сургалтын үйл ажиллагааны чанрыг сайжруулах багш нарыг бүлгийн зохион байгуулалтаар хамтарч ажиллах мэргэжил арга зүйгээр дэмжин ажиллах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д: “Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг

мөрдөж ажиллана”; /2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор баталсан “Ковид 19” цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”,
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” журам тайланд онд шинээр мөрдөгдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт нь үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын 2 дугаар цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 551,458.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 11,029.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 8,823.4 мянган төгрөгөөр төлөвлөлтийн материаллаг байдлын тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,665.5 мянган төгрөгөөр өссөн ба өмнөх оны үзүүлэлтээс материаллаг хэмжээний өөрчлөлттэй нь бараа материал, үндсэн хөрөнгийн дансд байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Бараа материал	45,355.2	40,832.0	(4,523.2)
Бусад эргэлтийн хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	1,532,739.4	1,549,928.2	17,188.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,578,094.6</b>	<b>1,590,760.2</b>	<b>12,665.6</b>
Богино хугацаат өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,578,094.6	1,590,760.2	12,665.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,578,094.6</b>	<b>1,590,760.2</b>	<b>12,665.6</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 40,832.0 мянган төгрөг болж 4,523.2 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 30,614.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон БСГ-аас 487.8 мянган төгрөгийн, сумын ЗДТГ-аас 423.5 мянган бараа материал үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 36,049.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,665,494.7 мянган төгрөг болж 45,521.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 4,695.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,000.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг худалдан авч, БШУЯ-наас 171.4 мянган төгрөгийн үнэ төлбөргүй тавилга үнэ төлбөргүй хүлээн авсан, аймгийн ОНӨГ-ын даргын 2021 оны 606 дугаар албан бичгийг үндэслэн 47,620.0 мянган төгрөгийн өртөгтэй газрыг орлогод авч, сумын ИТХ-ын 2021 оны 139 дүгээр тогтоолын дагуу 6,989.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан, 2,975.4 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийн үнэлгээг бууруулснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 12,665.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь

мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 627,867.9 мянган төгрөгөөр тооцон, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв батлахдаа төсвийн төслийг 116,990.6 мянган төгрөгөөр бууруулж, санхүүжилтийг 510,877.3 мянган төгрөгөөр баталсан. Төсвийн өөрчлөлтөөр тусгай зориулалтын санхүүжилтийг 44,015.7 мянган төгрөгөөр бууруулж, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 80,320.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр **547,182.1** мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 466,861.6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 80,320.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 466,861.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 43,971.3 мянган төгрөг, нийт 510,832.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 494,098.7 мянган төгрөг зарцуулан, улсын төсөвт 16,734.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **494,098.7** мянган төгрөг буюу 90.3 хувьтай тайлагнагдсан байгаа нь цалин, НДШ-ийн зардал 5,469.8 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 36,349.2 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 0.2 мянган төгрөгөөр, нормативт зардал 10,949.8 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 23.8 мянган төгрөгөөр, дотоод албан томилолтын зардал 204.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 85.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 126.0 мянган төгрөгийн орлого бүрдсэнээс хог хаягдал зайлуулах зардалд зориулалтын дагуу зарцуулжээ. .

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

1. БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай ” тушаалын нэгдүгээр хавсралт “*Коронавируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам*”-ын дагуу сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 148 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн тайлант оны үйл ажиллагаанд 547,182.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 494,098.7 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 9.7 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар 1 зөвлөмж өгөгдсөн бөгөөд зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт-2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	15,147.2	1	15,147.2			
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>15,147.2</b>	<b>1</b>	<b>15,147.2</b>			

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, бараа материалын нөөцийг бий болгосон шалтгаан зэргийг тодруулах нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21,028.5 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрснээс 1,550.1 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 19,478.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгсөн болно.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 1,550.1 мянган төгрөгийн дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлын дүнгээс татварын тайлан дахь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлын дүн 253.0 мянган төгрөгөөр, НДШ-ийн тайлан дахь цалингийн зардлын дүнг 1,285.9 мянган төгрөгөөр тус тус илүү илэрхийлсэн;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд ажил олгогчоос төлөх шимтгэлийг 11.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1 Төлбөрийн баримттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант онд 19,478.3 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

**2. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал:**

2.1. **Илрүүлэлт:** Шилэн дансанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

2.2 **Өгсөн зөвлөмж:** Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.1 дэх заалтыг зөрчсөн тул холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд нь шилэн дансанд мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ аймгийн Мандал сумын 2 дугаар цэцэрлэг	5	21,028.4	3	1,550.1	-	-	1	-	2	19,478.3

